



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

*ЦУВРАЛ №1*



2022 он

“Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулав.

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, 2022 ОН**



# ХУРИМТЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

**Хуримтлал гэдэг нь:** Богино, дунд, урт хугацааны хэрэгцээгээ хангах зорилгоор хуримтлуулж буй мөнгө, үнэт цаас болон бусад хөрөнгийг хэлнэ.



Хуримтлал  
үүсгэхийн тулд

1

Санхүүгийн зорилгоо  
тодорхойлно

2

Хуримтлал үүсгэх **орлогын эх үүсвэрээ төлөвлөнө** /цалин, бусад гэх мэт.../

3

Мөнгөний хэрэгцээт  
хугацааг төлөвлөнө


4

Хуримтлал өсгөх **боломжуудыг судална**

Богино хугацаа

Дунд хугацаа

Урт хугацаа



## Давуу тал



1. Санхүүгийн дарамтаас хамгаална



2. Нэмэлт орлого олно /хүүгийн орлого/

## Сул тал




1. Өндөр инфляциас шалтгаалж үнэ цэнэ буурах эрсдэлтэй



2. Хэрэглээ танаг дана

# ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ АЛХМУУД



  
**1. Зорилготой**  
хуримтлал үүсгэх

  
**2. Орлого, зарлагаа**  
тогтмол бичих

  
**3. Хэрэгцээ ба хүслээ**  
ялгах

  
**4. Харьцуулж худалдан**  
авалт хийж сурах


  
**5. Төлөвлөөгүй**  
худалдан авалт  
хийхгүй байх

  
**7. Цахилгаан, усаа**  
хэмнэх

  
**9. Даатгуулах**

  
**6. Гадуур**  
хооллохоо багасгах  
/Өдрийн хоолоо  
гэртээ бэлтгэх/

  
**8. Тэмдэглэлт**  
баяруудыг их зардлаар

  
**10. Дугтуйт**  
төсвийн арга  
ашиглах

  
**11. 52 долоо**  
хоногийн  
хадгаламж нээх



# ХЭРХЭН УХААЛАГ ЗЭЭЛ АВАХ ВЭ?

**Зээл гэдэг нь** банк, санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтыг

- тодорхой хугацаанд
- хүүний хамт
- эргүүлэн төлөх нөхцөлтэй авахыг хэлдэг.

Ирээдүйн орлоготойгоо уялдуулах



Тансаг хэрэглээнд бус, өөрийн зорилгоо биелүүлэхэд зээл авах



Өөрт хамгийн тохиромжтой эх үүсвэр сонгох



Одоогийн санхүүгийн байдлаа тодорхойлох



Зээлээр худалдан авалт хийхээс өмнө өөрөөсөө бататгах асуулт асууж хэвших



Та 2 болон түүнээс дээш асуултад **“ҮГҮЙ”** гэж хариулсан бол худалдан авалт хийхээ түр **“ХОЙШЛУУЛААРАЙ”**

- 1 Та **тогтвортой** ажил эрхэлдэг үү?
- 2 Танд цалингаас гадна **нэмэлт** орлогын эх үүсвэр байгаа юу?
- 3 Та сар бүр **тогтмол хуримтлал** үүсгэж чаддаг уу?
- 4 Танд худалдан авалт хийх **урьдчилгаа төлбөр** байгаа юу?
- 5 Таны **зээлийн түүх** сайн уу?
- 6 Таны “эр, орлогын эх үүсвэрийн харьцаа” **50 хувиас** бага уу?
- 7 Та өөрийн шийдвэртээ бүрэн дүүрэн **хариуцлага** хүлээхдээ итгэлтэй байна уу?

Зээл авахаар шийдсэн бол дахин нэг бодоод Үзээрэй



Зээлийн гэрээгээ битгий унш

Орлого байхгүй ч хүмүүсээс мөнгө зээлээд бай

Орлого, зарлагын жагсаалт гаргалгүйгээр хүссэнээрээ мөнгөө үр



Зээлээ хугацаанд нь төлөөд хэрэггүй

Нэмэлт орлогын эх үүсвэр хэрэггүй



# ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БА ЭРГЭН ТӨЛӨЛТ

**Зээлийн гэрээ гэдэг нь:** зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан мөнгийг тохирсон хугацаанд, хүүтэй буцаан өгөх үүргийг тусгасан баримт бичиг юм.

## Зээлийн бүтээгдэхүүний

талаар дэлгэрэнгүй

СУДЛАХ



Яаран гарын үсэг зурахаас

өмнө **зээлийн гэрээгээ**

сайтар УНШИХ




## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Ойлгохгүй заалтын

талаар банкны

ажилтнаас

зөвлөгөө аваарай.



## Эргэн төлөлтийн хуваарь нь

ирээдүйн орлоготой уялдаж

байгаа эсэхийг **НЯГТЛАХ**

## Хүүгийн төлбөр болон

гэрээний хариуцлагын

талаарх заалтыг **АНХААРАХ**

### Зээлийн эргэн төлөлтөө:



15–90 хоног хэтрүүлсэн бол : **анхаарал хандуулах буюу хугацаа хэтэрсэн**

91–180 хоног : **хэвийн бус**


181–360 хоног: **эргэлзээтэй**

361–ээс дээш хоног хэтрүүлсэн бол **муу зээл** болно.

“Хар жагсаалт” буюу “Зээлийн мэдээллийн сан”-д **хэвийн бус, эргэлзээтэй, муу** зээлүүд бүртгэгддэг ба зээлээ барагдуулж дууссанаас хойш **6 жилийн хугацаанд** бүртгэлтэй хэвээр байдаг.

Бүх санхүүгийн байгууллагууд нэгдсэн **зээлийн мэдээллийн сангаас** таны мэдээллийг авдаг гэдгийг санаарай.

“Хэрхэн ухаалаг зээл авах” талаар **ЗУРАГТ ХУУДАС №2-оос** мэдээлэл аваарай.



# ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХУВААРИЙН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Би зээлийн эргэн төлөлтөө ямар хэлбэрээр төлж болох вэ?

Таны орлогын эх үүсвэрээс хамааран дараах хувилбаруудыг санал болгож байна

Санхүүгийн байгууллага

Зээл

Хүүгийн төлбөр

1-р сар

2-р сар ..... сүүлийн сар

01

## Сар бүрийн тэнцүү төлбөр


/тогтмол цалинтай болон тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



02

## Сар бүр тэнцүү үндсэн зээлийн төлбөр

/тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/



03

## Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлээ хувааж төлөх

/улирлын шинж чанартай тогтмол бус орлоготой бизнес эрхлэгчдэд/



04

## Сар бүр зээлийн хүү + тодорхой саруудад үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөж, бусад хугацаанд зээлийн төлбөр тэнцүү

/улирлын шинж чанартай тогтмол орлоготой бизнес эрхлэгчдэд/





## ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

**Даатгал гэдэг нь:** Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа юм.



Даатгагдах эрсдэл



Хувь хүний эрсдэл



Эд хөрөнгийн эрсдэл



Хариуцлагын эрсдэл



Даатгагдахгүй эрсдэл



Элэгдэл, хорогдол



Техникийг шалган турших явцад гарсан хохирол



Сэтгэл санааны хохирол, байгууллагын нэр хүндийн эрсдэл



Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, байгууллагууд эрсдэлээ даатгуулж даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох үйл ажиллагаа юм.

## ХЭРХЭН ӨӨРТ ТОХИРСОН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ ЗӨВ СОНГОХ ВЭ?



# ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРӨӨ ХЭРХЭН АВАХ ВЭ?



Даатгалын гэрээний хүчинтэй хугацаанд



гэрээнд заасан даатгалын тохиолдол гарсан тохиолдолд



нөхөн төлбөрийг даатгагч олгодог.

**Жишээлбэл: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдол гарахад таны авах арга хэмжээ:**



1. Замын цагдаа, даатгалын компанидаа дуудлага өгөх



2. Ослын улмаас хүн бэртэж, гэмтсэн бол яаралтай түргэн тусламж дуудах



3. Дуудлага өгөх боломжгүй нөхцөлд орчны зураг авах, бичлэг хийх



Даатгуулагч хохирлын **нөхөн төлбөрийг төлүүлэхийн** тулд дараах **баримтыг бүрдүүлэх** шаардлагатай.

1. Даатгалын баталгааны эх хувь
2. Даатгуулагчийн өргөдөл
3. Эрх бүхий этгээдийн гаргасан дүгнэлт, акт, материал
4. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт (эмнэлэг, цагдаа г.м)

Нөхөн төлбөрийг **бүрэн буюу хэсэгчлэн олгохгүй** байх нөхцөл



1. Санаатайгаар хохирол учруулсан
2. Худал мэдээлэл, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн
3. Гарсан хохирлыг буруутай этгээдээр төлүүлсэн
4. Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй
5. Бослого, үймээнд оролцсоны улмаас хохирол үүссэн
6. Гэрээнд заасан хохирлын тохиолдлоос бусад



**Зөвлөмж**



Даатгалын гэрээг **сайтар уншиж танилцсанаар** гарын үсэг зурах



Даатгагч болон даатгуулагчийн **эрх, үүргийг мэддэг** байх



Даатгалын нөхөн төлбөр **олгох болон олгохгүй нөхцөлтэй** танилцах



Нөхөн төлбөр **олгох хугацаа, маргаан шийдвэрлэх талаар ойлголттой** байх



# ХУВЬЦАА ГЭЖ ЮУ ВЭ?

**Хувьцаа гэдэг нь:** компанийн тодорхой хэсгийг эзэмших эрхийг хэлэх буюу компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас юм.

## ХУВЬЦААНЫ ТӨРЛҮҮД

Үнэт цаас гаргагч компани **үндсэн 2 төрлийн** хувьцааг санал болгодог.

01

### Энгийн хувьцаа /common stock/

Энгийн хувьцаа эзэмшигч ихэнхдээ тухайн компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцох бөгөөд ногдол ашиг авах эрхтэй.

### Давуу эрхийн хувьцаа /preferred stock/

Давуу эрхийн хувьцаа эзэмшигч саналын эрхгүй боловч тогтмол хэмжээний ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчээс түрүүлж авах эрхтэй.

02

## ХУВЬЦААНЫ ДАВУУ БА СУЛ ТАЛ

### Давуу тал



1. Хөрвөх чадвар сайн
2. Ханшийн зөрүүнээс ашиг олох
3. Хувьцааны үнэ цэн өсөх магадлал их
4. Ногдол ашиг хүртдэг
5. Хөрөнгөө өөрөө удирдах боломжтой



### Сул тал

1. Хөрөнгө үнэ цэнээ алдах
2. Удаан хугацааны хүлээлт
3. Хадгаламжид байснаас эрсдэл өндөртэй
4. Гадаад, дотоод олон хүчин зүйлсээс хамаардаг
5. Компани нь дампуурах эрсдэлтэй

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ



Ээлжит болон ээлжит бус хуралд оролцох, санал өгөх



Компанийн тайлан мэдээлэлтэй танилцах



Эрх ашгаа хамгаалуулах талаар гомдол гаргах

## ҮНЭТ ЦААСНЫ ДАНС НЭЭХ ЗААВАР



Яаж данс нээдэг юм бол доо?  
.....

Би танд заагаад өгье.



### 01

Та өөрт тохиромжтой брокерын компанийг сонгоно.

### 02

Брокер дээр очиж, эсвэл цахимаар дансаа нээлгэнэ.

### 03

Хамгийн сүүлд нь данс нээлгэх хураамжаа **/5,000–10,000/** төлөөд л болоо



### АНХААРАХ ЗҮЙЛС:

- Мэдээллээ үзэн зөв бөглөх, мэдээллээ алдахаас сэргийлэх
- Гарын үсгээ зурахаас өмнө арилжааны шимтгэлийн хувь **/1–3%/**, хугацаа зэргийг сайтар анхаарах
- Арилжаанд орохдоо тухайн хувьцааны талаар судлах



## ӨРИЙН УРХИ ГЭЖ ЮУ ВЭ?

**Өрийн урхи гэдэг нь:** Зээл, хүүгийн төлбөрөө барагдуулж чадахгүй нөхцөл байдалд орохыг хэлдэг. Олон дахин зээл авах нь өрийн урхинд орох магадлалыг нэмэгдүүлдэг ба төдийлөн анзаарагддаггүй.

Та 4 болон түүнээс дээш асуултад **“ТИЙМ”** гэж хариулсан бол хувийн болон өрхийн санхүүдээ **АНХААРАХ ЦАГ БОЛСНЫГ ИЛТГЭНЭ.**

- 1 Та **байнгын хэрэгцээндээ** зориулж зээл авдаг уу?
- 2 Хэрэглээний төлбөрөө **хугацаа хэтрүүлэн** төлдөг үү?
- 3 Таны сар бүрийн тогтмол зардал, орлогын эх үүсвэрийн тань **50 хувиас** их байдаг уу?
- 4 Кредит картын эргэн төлөлтөө **хугацаа хэтрүүлэн** хийдэг үү?
- 5 Та зээлээ төлөхийн тулд **дахин зээл** авдаг уу?
- 6 **Ирээдүйн орлогоо** барьцаалан зээл авдаг уу?
- 7 Сар бүрийн тогтмол **зардлууд тань нэмэгдэж** байна уу?
- 8 Та кредит **картаар** байнгын хэрэгцээгээ хангадаг уу?
- 9 Өөрт байгаа техникийн хэрэгслээ **сайжруулах** зорилгоор **зээл** авдаг уу?
- 10 Банк таны зээлийн хүсэлтээс **татгалзаж** байсан уу?



Өрийн урхинд орсноор...

Хэрэглээ хумигдана

Хуримтлал үүсгэх чадамж буурна

Гэнэтийн үед дахин зээл авах боломжгүй болно

Сэтгэл санааны дарамт үүснэ

Зээлээ төлж чадахгүй болно



# ӨРИЙН УРХИНААС ХЭРХЭН АНГИЖРАХ ВЭ?

Аливаа зээлийг төлж барагдуулах, санхүүгийн тогтворгүй байдлаас гарахад нөлөөлөх чухал хүчин зүйл бол

**сайтар тооцоолсон төлөвлөгөө ба санхүүгийн сахилга бат юм.**



Зээлийн эргэн төлөлтийн график байгуулж сурах

Орлого болон зардлуудаа жагсаан бичих, хянах /Гар утасны платформууд/


Нэмэлт орлогын эх үүсвэртэй болж, зээлээ урьдчилан төлөх төлөвлөгөө гаргах

Өндөр хүүтэй зээлээ хамгийн эхэнд төлж барагдуулах

Нэмэлт зээл авахаас зайлсхийх



## ӨРИЙН УРХИНААС АНГИЖРАХ АРГУУД



Зээлийн эргэн төлөлтийг заасан хугацаанаас хэтрүүлэхгүй байх /Цалингийн данстай холбох/

Олон тооны жижиг зээлтэй бол нэгтгэх

Аливаа өвчин, бэртэл гэмтлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх

Гэнэтийн хэрэгцээнд зориулсан хувийн санхүүгийн төлөвлөгөө гаргах

Зээлийн хугацаагаа сунгахгүй байх



# САНХҮҮГИЙН ЛУЙВАР ГЭЖ ЮУ ВЭ?

**Санхүүгийн луйвар гэдэг нь:** банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэл ашиглан гайхалтай үр дүн амлах замаар бусдын эд хөрөнгийг завших үзэгдлийг хэлнэ.

## СҮҮЛИЙН ҮЕД ДЭЛГЭРЧ БУЙ ЛУЙВРЫН ТӨРЛҮҮД



### Хөрөнгө оруулалтын луйвар

Техник технологи эрчимтэй хөгжиж, хүн болгон хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон цаг үед тус луйврын хохирогчдын тоо нэмэгдсээр байна.

01

**Төрийн зохицуулалтгүй, урьдчилгаа төлбөр төлөхийг шаарддаг, хуурамч мэдээлэл ашиглан бусдаас хөрөнгө оруулалт татаж буй** луйврын эрсдэлээс урьдчилан сэргийлээрэй.



### Үл хөдлөх хөрөнгийн луйвар

Үл хөдлөх хөрөнгийн үнийн хэлбэлзэл ихээр нэмэгдэж байгаатай холбогдуулан луйврын тохиолдол өссөөр байна.

Хуурамчаар бичиг баримт үйлдэн өөрийн эзэмшлийн бус бусдын хөрөнгийг түрээслэх, дамлан худалдаалах, барьцаалан зээл авах гэх мэт луйврын эрсдэлээс урьдчилан сэргийлээрэй.

02



Албан ёсны зөвшөөрөлтэй зуулагчаар дамжуулах



Худалдан авалтын болон түрээсийн гэрээгээ судлах



Барилгын компаниа судлах

“Санхүүгийн луйврын нийтлэг төрлүүд, тэдгээрийн шинж”-ийн талаар **ДАРААГИЙН ЗУРАГТ ХУУДАСНААС** мэдээлэл аваарай.



# САНХҮҮГИЙН ЛУЙВРААС ХЭРХЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВЭ?

01

Хувийн мэдээллээ задруулахгүй байх

- Карт
- Интернет банк
- Бүх төрлийн нууц үг



02

Богино хугацааны сэтгэл хөдлөлд автахгүй байх



03

Эргэлзээтэй санагдвал татгалзах

Мэргэжлийн хүнээс зөвлөгөө авах



04

Маш сайн судалгаа хийх



05

Урьдчилж төлбөр төлөхгүй байх



**Санхүүгийн луйврын гэмт хэргийн талаар дараах байгууллагуудад мэдэгдэж болно.**



- Цагдаагийн ерөнхий газар
- Эрүүгийн цагдаагийн алба
- Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

Хэрэв та санхүүгийн луйврын хохирогч болсон тохиолдолд оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа шүүхэд өргөдөл гаргахыг зөвлөж байна.



# САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН НИЙТЛЭГ ТӨРЛҮҮД БА ТЭДГЭЭРИЙН ШИНЖ

## Понзи схем

### Урьдчилгаа төлбөрт луйвар

- Урьдчилан төлбөр төлөхийг яаруулдаг
- Судлах материал хомс



- Бага эсвэл ямар ч эрсдэлгүй өгөөж амладаг
- Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг
  - Нууцлагдмал, тодорхой мэдээлэлгүй
  - Хэт тогтмол өгөөжтэй байдаг



### Санхүүгийн пирамид

- Шинээр гишүүн элсүүлэхийг шаарддаг
- Бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаггүй
- Богино хугацаанд өндөр өгөөж амладаг



### Сургалтын луйвар

- Биелэхэд хэцүү зүйлийг амархан мэтээр үнэмшүүлдэг
- Өөр газраас үнэгүй олох мэдээллийг өндөр үнээр санал болгодог
- Яаруулж, бодох хугацаа олгодоггүй
- Дараа дараагийн сургалтад илүү өндөр үнээр хамрагдахыг шаарддаг
- Хуурамч мэдээлэл ашиглан сурталчилгаа хийдэг



### Памп & Дамп

- Зохицуулалт багатай зах зээл рүү чиглэдэг
- Богино хугацаанд өндөр өгөөж амладаг
- Зохицуулалт багатай цахим сүлжээгээр мэдээлэл түгээдэг /Telegram, Discord, .../
- Зохиомлоор үнэ цэнээ нэмэгдүүлэхийн тулд цуу яриа, ташаа мэдээлэл тараадаг
- Хүмүүсийн итгэлийг олохын тулд олны танил хүмүүсийг оролцуулдаг



## ШИНЭЭР БИЙ БОЛСОН ЛУЙВРЫН ТӨРЛҮҮД

### “Rug pull”

- Худал койн гарган хөрөнгө оруулагчдын мөнгийг залилдаг
- White paper нь хоёрдмол агуулгатай, эргэлзээ төрүүлэхүйц
- Сурталчилгаа маш ихээр хийдэг
- Өндөр өгөөж амладаг
- Хувьцааны үнэ ихээр хэлбэлздэг

### “Covid-19 scam”



- Цаг үеийн нөхцөл байдал эсвэл вакцины талаар мэдээлэл авахын тулд хувийн болон дансны мэдээллээ бичихийг шаарддаг
- Зах зээлээс хэт хямд үнээр эмчилгээний бүтээгдэхүүн зарахыг санал болгодог
- Дээрх тохиолдолд урьдчилгаа төлбөр шилжүүлэхийг шаарддаг

# ТҮҮХЭНД БҮРТГЭГДСЭН ХАЧИРХАЛТАЙ САНХҮҮГИЙН ЛУЙВРЫН КЕЙС



1821 онд Шотланд улсын иргэн болох Генерал Грегор Макгрегор Төв Америкаас Их Британи хүртэл завиар явахдаа **ПОЯИСЫН АРЛЫГ** нээн илрүүлжээ.

Тэрээр арлыг алтны нөөц ихтэй, хөрсний шим сайтай тул жилд 3 удаа ургац хураах боломжтой талаар дуулгахад **ХҮМҮҮС ИХЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ОДООГИЙН ХАНШААР 20 САЯ ДОЛЛАР** цугларсан.

**ГЭВЧ ЭНЭ БҮГД ЛУЙВАР БАЙСАН** ба бодит байдал дээр Пояис нэртэй ямар ч арал байгаагүй.



## ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ ЮУ?

Та 2 болон түүнээс дээш асуултад **“ТИЙМ”** гэж хариулсан бол **ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.**

- 1 Танд бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр өгөөж амлаж байна уу?
- 2 Таны хөрөнгө оруулах гэж буй салбар төрийн зохицуулалтгүй юу?
- 3 Таныг төлбөрөө төлөхийг яаруулж байна уу?
- 4 Танд асуулт асуух боломж олгож байна уу?  
Таны асуултад оновчтой хариулж байна уу?
- 5 Шагнал, бэлэг авахын тулд урьдчилгаа төлбөр төлөхийг шаардаж байна уу?
- 6 Одоо л ....-д хөрөнгө оруулахгүй бол “Сайхан боломжийг алдана” гэж шууд болон шууд бусаар үнэмшүүлж байна уу?





# САНХҮҮГИЙН ЭРСДЭЛЭЭС ХЭРХЭН ХАМГААЛАХ ВЭ?

**Санхүүгийн эрсдэл гэдэг нь:** хөрөнгө оруулж, хуримтлуулсан хөрөнгөө алдах болон алдаж болохуйц нөхцөл байдалд орохыг хэлнэ.

**Эрсдэл үүсгэж болох хүчин зүйлс:**



## Мэдээллийн хомс байдал

- Хангалттай мэдээлэл авсан эсэхээ нягтлах
- Харилцагч байгууллагаасаа нэмэлт мэдээлэл шаардах
- Харилцагч байгууллагын талаар судлах



## Хүлээгдээгүй үр дүн

- Эрсдэл, өгөөжөө тооцож, түүний алдах магадлалыг таамаглах
- Эдийн засгийн хүчин зүйлсийг тооцох



## Хэрэгцээндээ тохироогүй бүтээгдэхүүн сонгох

- Санхүүгийн зорилго, хэрэглээгээ нарийвчлан тодорхойлох



## Залилан болон хулгайд өртөх

- Нууц үгээ тогтмол шинэчлэх
- Даатгуулах

## “Эрх ашгаа хамгаалах”

талаар нэмэлт мэдээллийг дараах эх сурвалжаас унших боломжтой



Санхүүгийн эрсдэлээс хамгаалах гол арга нь **Та өөрийнхөө эрх ашгаа хамгаалахад анхаарах** юм шүү...



<http://www.frc.mn/a/3752>



<https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/31.pdf>



<http://www.frc.mn/resource/frc/File/2021/03/24/Inba51zy3icimsqa/garin%20avlaqa.pdf>





## САНХҮҮГИЙН ХОХИРОГЧ БОЛСОН НӨХЦӨЛД ХААНА ХАНДАХ ВЭ?

**1** Зохицуулалттай этгээд болон санхүүгийн үйлчлүүлэгч хооронд үүссэн маргаантай холбоотой асуудлаар доорх хуулийн хүрээнд **Санхүүгийн зохицуулах хороонд** өргөдөл гаргах /нөхөн төлбөр олгохгүй байх, үнэт цаас зөвшөөрөлгүй арилжих, зээлийн гэрээ гэх мэт/



Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль

Даатгалын тухай хууль

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль

Жолоочийн даатгалын тухай хууль

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль

### Өргөдөл гаргах хэлбэр



Бичгээр



Утсаар /51-261275/



Цахимаар

/http://www.frc.mn/i/Feedback/



Мөн **оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа шүүхэд** өргөдөл гарган, зохицуулалттай этгээд болон санхүүгийн үйлчлүүлэгч хооронд үүссэн **гэрээний маргааныг** шийдвэрлүүлж болно.

**2** Санхүүгийн асуудалтай холбоотой эрүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөлд өргөдлийг **харьяа аймаг, дүүргийн цагдаагийн газарт** гаргах



Бичгээр



И-мэйлээр  
/complaints@police.gov.mn/



Утсаар /102/

Гэмт хэргийн шинж чанараас хамааран **Эрүүгийн цагдаагийн алба, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар** өргөдлийг шийдвэрлэдэг.

**3** Санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч монопол давуу байдлаа урвуугаар ашигласан тохиолдолд **Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт** хандах




Бичгээр




И-мэйлээр  
/contact@afccp.gov.mn/



Утсаар /115/





# ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

*ЦУВРАЛ №1*



Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй  
дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia